



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/542

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", "Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт "Алтайн бөөрөг" ХХК-ний барьж гүйцэтгэсэн "Баруун бүсийн цаг, соёмбот цамхаг" босгох ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Улсын комиссын дарга: З.Өмиртай -Аймгийн Ерөнхий архитектор бөгөөд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Л.Батгэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, Төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Чанцал -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Ш.Мөнхзаяа -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

С.Батдорж -Аймгийн Архивын тасгийн дарга

Д.Гантулга -"Алтайн бөөрөг" ХХК-ний захирал

Г.Баатарболд -"Алтайн бөөрөг" ХХК-ний инженер

Нарийн бичгийн дарга: Д.Тогтохбаяр -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

D/Zax-A/542-Da

02 02685

2.Жаргалант сумын нутаг дэвсгэрт “Алтайн бөөрөг” ХХК-ний барьж гүйцэтгэсэн “Баруун бүсийн цаг, соёмбот цамхаг” босгох ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН

